



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/009/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дорнод аймаг

2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Нармандах

Утас: 7058-4207 Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг

Утас: 88883776 Цахим хаяг:

[khaanconsultingaudit@gmail.com](mailto:khaanconsultingaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал.....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	10
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн.....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
4.5.1 Завсрын аудитын талаар .....	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..	<b>Error! Bookmark not defined.</b>

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000  
Утас: 7058-4203

2026-03-13 № 354

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллагыг Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 07/09 дугаар тогтоолоор тус байгууллагыг татан буулган, хөрөнгийг Булган сумын Засаг даргын тамгын газарт шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудлууд**

Тус байгууллага нь орон нутгийн төсвөөс 100 хувь санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулдаг байсан.

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн жилийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2126050190

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	-
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.6	Бараа материал	31,934,320.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	31,934,320.00	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	107,309,164.64	-
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	107,309,164.64	-
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>139,243,484.64</b>	
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Өмч		
2.3.1	төрийн		
2.3.2	хувийн		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	139,243,484.64	
2.3.11	Эздийн өмчийн дүн		(139,243,484.64)
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>139,243,484.64</b>	

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	37,073,600.00	82,143,800.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг ( алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	-	-
8	Бусад орлого	140,669,318.00	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	-
11	Санхүүгийн зардал	38,499,433.36	124,754,079.14
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>38,499,433.36</b>	<b>124,754,079.14</b>
19	Орлогын татварын зардал	-	-

20	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>139,243,484.64</b>	<b>(42,610,279.14)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	139,243,484.64	-
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	96,633,205.50
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	139,243,484.64	(139,243,484.64)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	139,243,484.64	139,243,484.64
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(139,243,484.64)	(139,243,484.64)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
17	<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	-

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	37,073,600.00	82,143,800.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
1.2.1	Ажиллагчдад төлсөн	25,996,000.00	55,944,606.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,236,434.00	6,436,963.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	300,000.00	350,000.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	-	-
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,290,600.00	200,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	-
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,000,000.00	440,000.00

1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого / төвлөрүүлэг шилжүүлэг	5,250,566.00	16,272,331.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Татаас санхүүжилт орлого	37,073,600.00	82,193,800.00	82,143,800.00	50,000.00	99.9
Бусад орлого	140,669,318.00	-	-	-	-
<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>177,742,918.00</b>	<b>82,193,800.00</b>	<b>82,143,800.00</b>	<b>50,000.00</b>	<b>99.9</b>
Цалин хөлс	25,996,000.00	66,130,100.00	55,944,606.00	10,185,494.00	84.6
АО-аас НД-шимтгэлд төлөх зардал	3,236,434.00	9,523,700.00	6,436,963.00	3,086,737.00	67.6
Хангамжийн бараа материалын зардал	1,590,600.00	3,600,000.00	1,050,000.00	2,550,000.00	29.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	-	440,000.00	440,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,500,000.00	-	2,500,000.00	-
Элэгдлийн зардал	2,425,833.36	-	12,675,859.14	(12,675,859.14)	-
Бараа материал шилжүүлсний зардал	-	-	31,934,320.00	(31,934,320.00)	-
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>33,248,867.36</b>	<b>82,193,800.00</b>	<b>108,481,748.14</b>	<b>(26,287,948.14)</b>	<b>132.0</b>
<b>ТАТВАР</b>	-	-	-	-	-
<b>ТАТВАРЫН ДАРААХ АШИГ</b>	<b>144,494,050.64</b>	<b>0.00</b>	<b>-26,337,948.14</b>	<b>26,337,948.14</b>	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Компани, түүний үйл ажиллагаа**

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар статустай ба байгууллагын дүрэмд Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар гэсэн нэршилтэй байна. Байгууллагын дүрэмд тусгаснаар Дорнод аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид нь тус байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах, байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулах ба аймгийн Засаг даргын захирамжаар байгууллагын бүтэц, орон тоо төсвийн асуудлаар аймгийн Засаг даргад санал, зөвлөмж хүргүүлэх, аймгийн Засаг даргын багцад төсвийг суулгаж өгөхөөр зохион байгуулагдсан байна.

“Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ-ын зорилго нь ойн баялгийн нөөцийг судлан тогтоож хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн санг гэрээгээр иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, ойн санд учирсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ хийх бусад шаардлагатай мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд оршино.

#### **3.2 Компанийн гадаад, дотоод орчин**

Тус компани нь Орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай ууль, Ойн тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Байгууллагын дарга, нягтлан бодогч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтын талаар олж авсан ойлголтод үндэслэн, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус салбар компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт стандартад нийцэхгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

“Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгээгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139,243.5 мянган төгрөгөөр буюу 100 хувиар буурсан нь бараа материал, үндсэн хөрөнгө дансанд материаллаг өөрчлөлт гарснаас шалтгаалсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Өөрчлөлт /хувь/
<b>Б</b>	1	2	3=2-1	4=2/1
Бараа материал	31,934.3	-	(31,934.3)	(100.0)
Үндсэн хөрөнгө	107,309.2	-	(107,309.2)	(100.0)
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>139,243.5</b>	<b>-</b>	<b>(139,243.5)</b>	<b>(100.0)</b>
Өр төлбөр	-	-	-	
Эздийн өмчийн дүн	139,243.5	-	(139,243.5)	(100.0)
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>139,243.5</b>	<b>-</b>	<b>(139,243.5)</b>	<b>(100.0)</b>

Тус байгууллага нь Төрийн сангийн 1 харилцах данстай ба улсын бүртгэлийн гэрчилгээнд эдгээр дансыг бүртгүүлээгүй байна.

Бараа материалын дансны хувьд тайлант онд үлдэгдэлгүй болсон нь өмнөх оны 31,934.3 мянган төгрөгийн дуусаагүй үйлдвэрлэлд бүртгэлтэй мод ургамлыг татан буугдаж Булган сумын ЗДТГ-т балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс үлдэгдэлгүй болж 107,309.2 мянган төгрөгөөр буурсан нь тус байгууллага татан буугдахтай холбоотой Булган сумын ЗДТГ-т балансаас балансад шилжүүлснээс шалтгаалжээ.

Эздийн өмчийн үлдэгдэлгүй болсон нь тайлант хугацаанд бараа материал, үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлснээс гол нөлөө үзүүлжээ.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ -ын дарга нь байгууллагын техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлаагүй ба төсөвт байгууллагын адил тайлант хугацааны өөрийн үйл ажиллагаагаар олох орлого, зарцуулах зардал, татаас санхүүжилтийг баталсан байна. Тайлант онд орон нутгийн төсвөөс нийт орлогыг 82,193.8 мянган төгрөг, нийт зардлыг 82,193.8 мянган төгрөг ашгийн хэмжээг тогтоогоогүй, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд төлөвлөөгүй байна.

Гүйцэтгэлээр 82,143.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 108,481.7 мянган төгрөгийн зардал гарган, 26,337.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 82,143.8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 50.0 мянган төгрөг буюу 0.06 хувиар буурсан нь Аймаг төсвөөс дутуу санхүүжилт олгосонтой холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 108,481.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 31.9 хувиар их байгаа нь тайлант хугацаанд татан буугдаж бараа материал дансанд бүртгэлтэй 31,934.3 мянган төгрөгийн мод ургамлыг шилжүүлснээс шалтгаалжээ.

Тус байгууллага нь зорилтот түвшний гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталдаггүй, тайлант хугацаанд ашигтай ажиллах зорилт тавьдаггүй, төсөвт байгууллагатай адилаар төсөв баталдаг.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ-ын түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор Ч.Баярсайхан, аудиторын туслах Э.Тунгалагтамир нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хаан консалтинг аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Ганцэцэг, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Нармандах, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

“Булган сум дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ нь 2025 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн тайлангийн батлагдсан үйл ажиллагааны зардлын дүнгийн 82,193.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,232.9 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд тус байгууллага нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй, үр дүн гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн**

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн 8 судалгаанаас дараах 2 нь хамааралтай байна. Үүнд:

1. *Дараалсан 3 жилийн ашиг, алдагдал:* 2023-2025 онуудын ашиг, алдагдлыг харьцуулахад тус байгууллага нь 2024 онд үүсгэн байгуулагдсан ба 2024 онд 139,243.5 мянган төгрөгийн ашигтай, тайлант онд 42,610.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тус байгууллага орлогын дэлгэрэнгүй тайланд дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгүүд бүртгэж, элэгдэл тооцсоноос шалтгаалжээ.
2. Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүн нь санхүүгийн тайлангийн төрийн өмчийн дүнтэй тохирч байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Засварын аудит хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан ба Шилэн данстай холбоотой 19,525.9 мянган төгрөгийн албан шаардлага өгснийг хэрэгжсэн байна.

##### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тус байгууллага нь татан буугдаж үйл ажиллагаа зогссон байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар хаалтын тайланг баталгаажуулав.